



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/593

Есөнбулаг

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн 20220502/04-217 дугаар гэрээт Бигэр, Цогт, Тайшир, Дэлгэр сумдад 6 ширхэг инженерийн хийцтэй гүний худаг гаргах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Б.Цэрэндаваа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга угсралт техник хяналт хариуцсан мэргэжилтэн)

Ч.Нямдорж (Бигэр, Дэлгэр, Тайшир, Цогт сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар ("Сойл инжинеринг" ХХК-ийн гүйцэтгэх захирал) (гүйцэтгэгч талаас)

Нарийн бичгийн дарга: Э.Пүрэвдорж (Хүнс, хөдөө аж ахуйн газрын малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Худгийг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсаны дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Т.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг паспортжуулан бүртгэж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

